



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/108

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 5 иргэн, 1 аж ахуйн нэгжийн нийт 0.3558га /3558м<sup>2</sup>/ газрыг хавсралтад дурдсанаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 04-ны өдрийн  
А/108 дүгээр захирамжийн  
хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшү үлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Гөрөөчин овгийн Цэрэнчимэд Баярсайхан /РЭ63032312/	Барчуул овгийн Зоригоо Борбанди /РЛ99050718/	6712016182	Гэр, орон сууцны хашааны газар	1-р баг Гандан-3 307 тоот	500	13	Аймгийн Засаг даргын 2020.10.20-ны өдрийн А/530 дугаар захирамжийн хавсралтын 9 дэх заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Балдир овгийн Отгой Баянмөнх /РИ80030410/	Дунд хариад овгийн Жамсрансүрэн Лхагвасүрэн /РУ84042501/	6712017042	Гэр, орон сууцны хашааны газар	13-р баг 26-4 тоот	471	31	Аймгийн Засаг даргын 2022.01.04-ны өдрийн А/03 дугаар захирамжийн холбогдох хэсэг	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	Ач хариад овгийн Бадрах Лхамсүрэн /РЮ49050111/	Барнууд овгийн Гомбосүрэн Цэдэндамба /РЮ53101701/	6712017170	Гэр, орон сууцны хашааны газар	8-р баг 9-49 тоот	1497	20	Сумын Засаг даргын 2006.08.03-ны өдрийн №90 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 7 дахь заалт	Өвлөх эрхийн гэрчилгээг эр газар эзэмших хугацаа сунгах
4	Чачирт овгийн Пүрэвсүрэн Жамба /РЗ75111312/	Анчин овгийн Жүгдэр Батаа /РБ81082911/	6712015772	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	7-р баг "Хаан банк"-ны хашаанд	150	39	Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/162 дугаар	Газар эзэмших эрх шилжүүлэх

*(Handwritten signature)*

								захирамжийн хавсралтын 2 дахь заалт, 2021.02.22-ны өдрийн А/99 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь заалт	гэрээгээр
5	Тогоруутан овгийн Замбал Бурмаа /РП69071209/	Хар сүрэгтэн овгийн Баавгай Баасанжав /РЭ80071806/	6712017162	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	8-р баг 13 дугаар байр 27 тоотны өргөтгөл	26	15	Аймгийн Засаг даргын 2011.05.30-ны өдрийн А/186 дугаар захирамжийн хавсралтын 8 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
6	"Голомт банк" ХХК-Банк /РД:2075377/	Мянгат овгийн Сэрээтэр Оюунчимэг /РЮ65100861/	6712012153	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	7-р баг 29-13 тоот	914	26	Аймгийн Засаг даргын 2017.12.07-ны өдрийн А/825 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 3558м<sup>2</sup>

-----oOo-----